

МОНГОЛ, ОРОС, ХЯТАДЫН ЭРДЭМТДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА ГҮНЗГИЙРЧБАЙНА

*Л.Бэгзжав**

Анх 2008 оны 6-р сард Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор БСШУЯ, Гадаад Харилцааны Яам, ШУА хамтран “Монгол, Орос, Хятад: XXI зуунд хөгжлийн төлөө хамтдаа” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар форумыг хийсэн билээ.

Гурван талын 2-р форумыг Хятадын Нийгмийн ШУА-ийн Ази, Номхон Далайн хүрээлэнгээс эрхлэн Хятадын нийслэл Бээжин хотноо 2009 оны 6-р сарын 9-10-нд зохион байгуулсан юм.

Монгол, Орос, Хятадын гурван талын болон хоёр талын харилцаа, Зүүн хойт Азийн олон улсын харилцаа, үндсэн хандлага, тулгамдаж буй асуудал, хэтийн төлөв, гурван талын эдийн засаг, худалдаа, хамтын ажиллагааны одоогийн байдал, хандлага, соёлын хамтын ажиллагаа зэрэг өргөн хүрээтэй асуудлаар гурван орны эрдэмтэд санал бодлоо солилцож, эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээ “Монгол, Орос, Хятад: XXI зуунд хөгжлийн төлөө хамтдаа” УБ, 2009, “Китай, Монголия, Россия: мир, развитие и сотрудничество” Пекин, 2009 гэсэн хоёр ном болгон орос, монгол, хятад, англи хэлээр Улаанбаатар, Бээжин хотноо хэвлүүлж, уншигч олны хүртээл болгосон юм.

“Монгол, Орос, Хятад: орчин үед хамтдаа” сэдэвт Орос, Хятад, Монголын гурван талын эрдэм шинжилгээний 3 дахь форум 2011 оны 6-р сарын 9-10-нд Оросын Холбооны Улсын нийслэл Москва хотноо амжилттай болж өнгөрлөө.

Энэ удаагийн “Монгол, Орос, Хятадын эрдэмтдийн 3-р форумыг ОХУ-ын Дорнодахины хүрээлэн зохион байгуулж, гурван талын 24 илтгэл сонсож хэлэлцлээ. Илтгэлийн гол агуулга нь:

1. Зүүн Хойт Азийн бүс нутаг дахь олон улсын харилцааны өнөөгийн байдал, хэтийн төлөв. ЗХА дахь энх тайван, аюулгүй байдалд тулгарч буй аюул занал, түүнийг зайлуулах хамтын, зохицуулсан үйл ажиллагааны шинэ боломжийг эрж хайх явдал
2. “Монгол, Орос, Хятадын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн хандлага, хэтийн төлөв, “Монгол, Орос, Хятадын хоорондын хоёр талын ба гурван талын худалдаа, эдийн засгийн харилцааны асуудал, хэтийн төлөв
3. Гурван улсын хоорондын шинжлэх ухаан, соёлын салбар дахь хоёр талын ба гурван талт хамтын ажиллагааны

* Л.Бэгзжав - ОУСХ-ийн Хятад судлалын салбарын эрхлэгч, доктор (Ph.D), профессор

байдал, тулгарч буй асуудал, хэтийн төлөв. Баруунжсан постмодернизмын тархалт ба даяаршилын нөхцөл дэх үндэсний соёлыг хамгаалах асуудал зэрэг болно.

Хуралд Оросын талаас дараахь илтгэлийг тавьж хэлэлцүүлэв. Үүнд:

- “Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим ба бүс нутгийн хамтын ажиллагааны асуудал” /ОХУ-ын Гадаад Харилцааны Яамны дэргэдэх Москвагийн олон улсын харилцааны улсын институтийн Дорнод Ази ба ШХАБ-ын судалгааны Төвийн ахлах ажилтан, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Б.Я.Воробьёв/
- “Дорнод Ази: 2010 оны дүн, Орос, Монгол, Хятадын хамтын ажиллагааны хөгжлийн шинэ боломж”. /Оросын ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн /ДДСХ/ Монгол, Солонгос судлалын салбарын эрхлэгч, доктор А.В.Воронцов/
- “XX зууны эцэс ХХI зууны эхэн дэх Орос-Монгол, Монгол-Хятадын харилцааны тухай Өрнөдийн зохиогчид” доктор М.И.Гольман /Оросын ШУА-ийн Дорнодахин судлалын хүрээлэн/
- “ЗХА дахь интеграцийн үйл явцын хүрээн дэх Орос ба Хятад” /ОХУ-ын ГХЯ-ны ажилтан С.С.Суслина/
- “Орос, Хятад, Монгол: түүхэн ба орчин үеийн харилцан ажиллагаа ШХАБ-ын хэмжигдэхүүн” /С.Г.Лузянин түүхийн шинжлэх ухааны доктор, профессор. Оросын ШУА-ийн Алс Дорнодын институтийн /АДИ/ 1-р орлогч захирал, ОХУ-ын Аюулгүй байдлын Зөвлөлийн дэргэдэх эрдмийн зөвлөлийн гишүүн/
- “Дорнод Сибирь, Байгалийн чанад дахь эдийн засгийн байдлын түвшинг үнэлэх нь” (Д.В.Гордиенко цэргийн шинжлэх ухааны доктор, профессор /АДИ/)
- “Төв ба Зүүн Хойт Ази дахь аюулгүй байдлын асуудал” (А.Ф.Клименко доктор, профессор /АДИ/)
- “Их Ойрхи Дорнод буюу Монголын “Гурав дахь хөрш” (О.В.Зотов доктор /ДДСХ/)
- “Хөдөө аж ахуйн хөгжил бол Орос, Хятад, Монголын урт хугацааны хамтын ажиллагааны стратеги мөн” (В.А.Акимов доктор, /ДДСХ/)
- “Орос-Хятадын бүс нутаг хоорондын ба хил орчмын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа”. (М.В.Александрова доктор, /АДИ/)
- “Бүс нутгийн түвшин дэх Орос, Монголын харилцааны өнөөгийн байдал, тулгарч буй асуудал, хэтийн төлөв”.

- (Г.Г.Васильев Байгалийн чанад дахь хүмүүнлэг-сурган хүмүүжүүлэх ухааны Улсын Их сургуулийн ЗХА-ийн олон улсын судалгааны төвийн захирал, профессор)
- “Байгалийн чанад дахь хил орчмын шинжлэх ухаан, боловсролын салбар дахь Орос-Хятадын харилцааны өнөөгийн байдал”. (Мөн сургуулийн доктор, доцент В.В.Кузнецов)
 - “Орос, Хятад, Монголын хамтын ажиллагааны боломж ба ЗХА дахь экологийн аюулгүй байдлын асуудал”. (Оросын ШУА-ийн ДДСХ-ийн Монгол, Солонгос судлалын эрдэм шинжилгээний ахлах ажилтан доктор Е.В.Бойкова)
 - “Монгол, Оросын соёл иргэншлийн ижил чанар: ижил төстэй асуудал” (А.С.Железняков Оросын ШУА-ийн Социологийн хүрээлэнгийн Улс төр судлал, улс төрийн социологийн төвийн удирдагч, улс төрийн шинжлэх ухааны доктор)
 - “Зүүн Хойт Ази дахь “Зөөлөн хүч”: Оросын зорилт (Г.Д.Толорая “Русский мир” Ази, Африкийн фондын бүс нутгийн захирал, доктор, профессор, Н.Н.Толорая (БНСУ. Сөүл Хангук Их сургуулийн профессор)
 - “Орос (Халимаг) - Монгол (Баруун аймгууд) - Хятад (Синьзян-Уйгурын автономит район): Боловсрол, соёлын салбар дахь хамтын ажиллагаа”. (К.В.Орлова. ДДСХ, Түүхийн шинжлэх ухааны доктор)
 - “Толь бичиг бол соёлын харилцан ярианы үндэс мөн” (А.И.Ковзев философийн ухааны доктор ДДСХ) зэрэг илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Гурван талын форумд БНХАУ-ын талаас Хятадын Нийгмийн ШУА-ийн Ази-Номхон далайн хүрээлэнгийн захирал профессор Ли Сянян, мөн хүрээлэнгийн профессор Пяо Гуанзи, профессор Пяо Зяньи, доктор Фу Зинюнь нар оролцож, “Зүүн Хойт Азийн олон улсын харилцааны өнөөгийн байдал, хэтийн төлөв”, “Зүүн Хойт Ази дахь худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааны механизмыг дотоод бүс нутгийн худалдааны үүднээс авч үзэх нь”, “Эрчим хүчний салбар дахь Хятад-Оросын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, тулгарч буй асуудал” гэсэн сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлсэн нь амжилттай боллоо.

Тус Форумд Монголын талаас ОУСХ-гийн захирал доктор (Sc.D), профессор Л.Хайсандай “Зүүн Хойт Ази дахь Монгол Улсын хамтын ажиллагаа ба аюулгүй байдлыг хангах нь”, мөн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга доктор Д.Шүрхүү “Монгол-Хятад: стратегийн түншлэл ба чөлөөт худалдааны тухай хэлэлцээр”, Орос судлалын салбарын эрхлэгч доктор (Sc.D) О.Батсайхан “Нефтийн салбар дахь Монгол,

Оросын хоёр талын хамтын ажиллагаа”, Хятад судлалын салбарын эрхлэгч доктор, профессор Л.Бэгзжав “Стратегийн түншлэлийн шатан дахь өнөөгийн Монгол, Хятадын харилцааны зарим асуудал” сэдвээр тус тус илтгэл тавьсан нь форумд оролцогчдын анхаарлыг татаж, тэднээс өндөр үнэлэлт авсан юм.

Монгол, Орос, Хятадын эрдэмтдийн хамтын ажиллагаа, судалгааны үр дүнг форумд оролцогчид өндөрөөр үнэлж, гурван улсын нийслэл хотноо ээлжлэн болсон энэхүү форумыг үргэлжлүүлэн дараагийн ээлжит форумыг Монгол Улсад 2013 онд хийхээр тогтлоо.